

**“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025.04.29

Дугаар 01

Улаанбаатар хот

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Махатма Гандийн гудамж 39, Корпорэйт конвеншн центрийн “Эвэнт холл” танхимд 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 9 цагаас хосолсон хэлбэрээр 94.38 хувийн ирцтэйгээр эхлэв.

Хурлын дарга:
Хуралд оролцсон:

Б.Тэлмүүн– ТУЗ-ийн дарга
Г.Золбоо– ТУЗ-ийн гишүүн
Х.Пүрэвсүрэн– ТУЗ-ийн гишүүн
С.Цэнд-Аюуш– ТУЗ-ийн хараат гишүүн
З.Оюунцацрал-ТУЗ-ийн хараат бус гишүүн

Хурал зохион байгуулах комисс

Комиссын дарга:

Д.Сугар– Бизнес хариуцсан ГЗ-ын тэргүүн орлогч

Комиссын орлогч дарга:

Э.Ханга – Засаглалын албаны ахлах хуульч

Комиссын гишүүд:

Э.Уянга– ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Б.Амарсанаа – Хууль, эрх зүй хариуцсан дэд захирал
Н.Энх-Амгалан– Цахим банкны газрын захирал
Г.Содонбаатар– МОНХГ-ын захирал
Т.Чин-Эрдэнэ– ДАГ-ын МТАТХ-ийн захирал
Г.Баясгалан–ЗА-ны ахлах мэргэжилтэн
Б.Лундаа- ЗА-ны хуульч
С.Билэгсайхан- Хөгжүүлэлтийн хэлтсийн программ зохиогч
С.Оюун-Эрдэнэ– ХЗГ-ын дилер

Комиссын нарын бичгийн дарга:

Хурлын тооллогын комисс

Комиссын дарга:

А.Батмөнх– ДХШГ-ын захирал

Комиссын гишүүд:

О.Баасансүрэн– ХҮЧБУГ-ын захирал
Б.Цэндсүрэн– Хөгжүүлэлтийн хэлтсийн захирал
А.Бямбазориг– ДХШГ-ын ахлах хянан шалгагч

Комиссын нарийн бичгийн дарга:

Л.Булгаа– ХҮА-ны менежер

ХЭЛЭЛЦСЭН нь:

ТАНИЛЦАХ АСУУДАЛ:

1. “Төрийн банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
2. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай танилцуулга;
3. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “Төрийн банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл.

СОНССОН нь:

А.Батмөнх, Тооллогын комиссын дарга: Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхнийг суудлаа эзлэхийг урьж байна. “Төрийн банк” ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэндийг хүргэе. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөр бүртгэлийн өдрийг тасалбар болгон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлсэн бөгөөд “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн эзэмшлийн хувьцааны тоог танилцуулбал Сангийн яам 49,26% Хадгаламж даатгалын корпораци 45,03 олон нийт 5,71%-ийг тус тус эзэмшиж байна. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүнийг ахалж ажиллаж байгаа А.Батмөнх миний бие хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг та бүхэнд танилцуулъя. 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр №01 Улаанбаатар хот, ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүчин төгөлдөр болсныг батлах тухай тогтоол. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн тогтоох нь: “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй нийт 755,096,250 ширхэг хувьцаанаас тус хуралд саналын эрх бүхий 712,684,913 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч хуралд оролцсоноор нийт саналын эрхтэй хувьцааны 94,38% болж хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах ирц бүрдэж хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай. Тооллогын комиссын дарга А.Батмөнх гишүүд О.Баасансүрэн, Б.Цэндсүрэн, А.Бямбазориг, нарийн бичгийн дарга Л.Булгаа. “Төрийн банк” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 40 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагааг албан ёсоор удирдан нээж өгнө үү хэмээн “Төрийн банк” ХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн таныг тайзнаа урьж байна.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, хатагтай, ноёд та бүхэнд өглөөний мэндийг хүргэе. Төрийн банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэнд та бүхэнд баярлалаа. Бид өнгөрсөн онд бизнесийн хамтрагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгаль орчинд ээлтэй, хүний эрхийг дээдэлсэн, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, ногоон хөгжил, дундаж давхаргыг, бойжуулах, дэмжихэд чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт цахим технологи ашиглан тогтвортой, хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх зорилгыг эрхэмлэн ажилласны үр дүнд банкны нийт актив 6.2 их наяд төгрөг, нийт зээл 3.5 их наяд төгрөгт хүрч, 107.9 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаж чадлаа. Төрийн банк нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган, Монголын Хөрөнгийн биржийн ТОП-20 индекст жил дараалан багтаж, засаглалын олон улсын туршлага, дотоодын эрх зүйн баримт бичгийг мөрдлөг болгон сайн засаглалыг өргөжүүлэн бэхжүүлж ажилласны үр дүнд нэгж хувьцаанд 2022 онд 63.68 төгрөг, 2023 онд 66.20, 2024 онд 63.70 төгрөг хуваарилан бүрэн олгож, улмаар хувьцаа эзэмшигч нартаа ногдол ашиг тарааж хэвшсэн нь банкны үйл ажиллагааны үр дүнг илтгэх томоохон үзүүлэлт гэж үзэж байна. Төрийн банк нь өмнөх жилүүдэд дэвшүүлсэн дундаж давхаргыг дэмжих эрхэм зорилгоо бататган, Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргээ үргэлжлүүлэн хүргэхийн зэрэгцээ төрөөс хэрэгжүүлж буй бодлого, зорилтын хүрээнд ногоон хөгжлийг тусгайлан дэмжих чиглэлийн шинэ, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд санал болгон, дэмжлэг үзүүлж ажиллахаар эхний шатны арга хэмжээг авч хэрэгжүүлж эхлээд байна. Та бидний хамтын банкны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ил тод байдал, үр ашгийг нэмэгдүүлэх талаар бодлогын томоохон өөрчлөлтийг хийж, санхүүгийн салбарт тогтвортой хөгжил, хариуцлагатай бизнесийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, оролцогч талуудын ил тод байдлыг хангах, хүлэмжийн хийн ялгарлыг олон улсын аргачлалын дагуу тооцон тайлагнах, уур амьсгалтай холбоотой шилжилтийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг байгальд ээлтэй санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх хүндтэй бөгөөд амаргүй үүргийг гүйцэтгэхээр болж байна. Ирэх жилүүдэд бид ил тод, нээлттэй, хариуцлагатай, шилэн, үндэсний хэмжээнд тэргүүлэгч банкийг хөгжүүлэн, бэхжүүлэх том сорилтын өмнө зогсож байгаа бөгөөд Төрийн банкны хувьцаа эзэмшигчид Та бүхний дэмжлэг, үр дүнтэй санал, санаачилгад тулгуурлан энэхүү сорилтыг даван, шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлтийг амжилттай хийж чадна гэдэгт бид бүрэн итгэж байна. Төрийн банкны хувьцаа эзэмшигч, харилцагч, бизнесийн хамтрагч та бүхэнд бидний ажлыг тууштай дэмжиж, итгэл үзүүлж байдагт талархлаа илэрхийлэн Та бүхний цаашдын ажил, бизнесийн үйл ажиллагаанд амжилт бүхнийг хүсэн ерөөе. Төрийн банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагааг нээснийг үүгээр мэдэгдье.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Хурлын хөтөлбөр ёсоор өнөөдөр 3 танилцах асуудал, 1 хэлэлцэн батлах асуудал байгаа. Та бүхэнд материалыг тараасан байгаа. Танилцах асуудлын хувьд 1 дүгээрт, Төрийн банкны 2024 оны үйл ажиллагааны болон

санхүүгийн тайлангийн танилцуулгыг Гүйцэтгэх захирал Ө.Гантөр, 2 дугаар асуудал болох 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай танилцуулгыг миний бие хийнэ. 3 дугаарт, хувьцаа эзэмшигчдэд 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай танилцуулгыг мөн миний бие танилцуулна. 4 дэх асуудал, Төрийн банкны 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслийг өнөөдөр бид хэлэлцэн батлах юм. Өнөөдрийн эхний асуудалдаа хөтөлбөр ёсоор оръё. Төрийн банкны 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулахаар Гүйцэтгэх захирал Ө.Гантөрийг индэрт урьж байна.

Нэг. “Төрийн банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Төрийн банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн Төрийн банкны хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төрийн банкны 2024 оны санхүү болон үйл ажиллагааны тайланг танилцуулъя. 2024 он маань болбол онцлог жил байсан. Монгол Улсад банкны систем үүсэж хөгжсөний 100 жилийн ой мөн Төрийн банк үүсэн байгуулагдсаны 15 жилийн ой тохиосон, та бүхэндээ 15 жилийн ойн баярын мэндийг хүргэе. Төрийн банк маань үүсгэн байгуулагдсан он цаг буюу 2009 онд 130 гаруй тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэй үйл ажиллагаа эхэлж байсан болбол өнөөдөр 6 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулж байна. Өнөөдөр 6 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй үндсэндээ банкны системийн нөлөө бүхий 5 том банкны нэг, мөн дээрээс нь Хөрөнгийн бирж дээр, хөрөнгийн зах зээл дээрх Топ-20 буюу энэ индексийн эхний 10-15-д нь жагсаж байгаа ийм үзүүлэлттэй байна. Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд 2021 онд Банкны тухай хууль шинэчлэгдэн батлагдсан. Үүний дагуу 2022 онд Төрийн банк анх хөрөнгийн зах зээл дээр хувьцаа гаргаж арилжсан байгаа. 5,71% буюу 25,4 тэрбум төгрөгийн хөрөнгийг босгосон. Ингэснээр ганцхан төрийн өмчид байсан бол, олон нийт 5,71%-ийг эзэмшсэнээр Сангийн яам 49,26% Хадгаламжийн даатгалын корпораци 45,03%-ийг эзэмшиж байна. Бүтэц зохион байгуулалтын хувьд 2024 онд томоохон өөрчлөлт бол ороогүй байгаа. Удирдлагын хувьд бол 4, газар 17, хэлтэс 22, 10-н алба, 497 салбар нэгж буюу Улаанбаатар хотод 83 салбар нэгж орон нутагт 413 салбар нэгж БНСУ-д 1 төлөөлөгчийн газартайгаар үйл ажиллагаа явуулж байна. Банкны хувьд нийт 3373 ажилтан ажиллаж байгаа. Үүнээс 728 ажилтан Улаанбаатар хотод, 1986 ажилтан орон нутагт, 659 ажилтан банкны төв дээр ажиллаж байгаа. Энэ дээр нэг зүйлийг онцолж хэлэхэд болбол БНСУ-д 2 банк албан ёсны зөвшөөрөлтэй төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулж байгаа. Тэрний нэг нь Төрийн банк. БНСУ-д 50 мянга гаруй манай Монгол Улсын иргэд ажиллаж амьдарч байгаа. Эдгээр иргэддээ бид нар банкны санхүүгийн үйлчилгээг хүргэх тал дээр нэлээдгүй ач холбогдол өгч ажиллаж байгаа. Мөн 2024 оноос эхэлж энэ төлөөлөгчийн газраа салбар болгохоор ажиллаж байна. Зохицуулагч байгууллагаас холбогдох бичиг баримтуудыг үндсэндээ аваад БНСУ руу бичиг баримтаа бүрдүүлээд явж байгаа. Ололт амжилтын хувьд 2009 оноос хойш 15-16 жилийн хугацаанд нэлээдгүй амжилтыг

бид бүхэн хамтран бүтээсэн цогцлоосон байгаа. Үүн дотроо бол 2024 онд бид бүхэн Мүүдис байгууллагаар зээлжих зэрэглэлээ тогтоолгож B2 буюу тогтвортой гэсэн ийм үнэлгээг авсан байгаа. Энэ нь бол мэдээж гадаад, дотоодын байгууллагуудаас санхүүгийн эх үүсвэрийг татах, хамтран ажиллахад нэлээдгүй эерэг нөлөө үзүүлэхээр ийм үзүүлэлт байгаа. Дараагийн хамтран ажиллаж байгаа байгууллага болбол Frontcler гээд компани байгаа. Бид нар 2018 оноос хойш хамтран ажилласан. Анх Монгол Улсад 25 сая долларын репо хэлцлийг бол анх Монгол Улсад хийж байсан бол өнөөдөр бид 2024 онд 105,9 тэрбум төгрөгөөр эх үүсвэрийг татсанаараа энэ нь бол Монгол улсад төгрөгийн эх үүсвэрийг гаднаас татсан анхны банк болж амжилттай татсан байгаа. Энэ эх үүсвэрээ бид нар дотооддоо зээлийн үйл ажиллагаандаа зарцуулж байна. Банкны хувьд сүүлийн үед ялангуяа цахимжих энэ үйл ажиллагааг эрчимтэй хийж байгаа. Үүний үр дүнд бүтээгдэхүүн үйлчилгээний 80 гаруй хувь нь болбол цахимжсан. Цахимжих хэрээр мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах шаардлага үүссэн. Үүний хүрээнд бид мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартыг банкандаа нэвтрүүлээд байгаа. Ингэснээр Кибер аюулгүй байдлын тухай хуулийн холбогдох шаардлагуудыг бүрэн хангаж ажиллах ийм нөхцөл бүрдсэн байгаа. 2024 онд Монгол Улсын Засгийн газраас Төрийн банкныг ногоон хөгжлийг дэмжигч банк болгож зарласан. Үүний хүрээнд Төрийн банк холбогдох дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөөндөө холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг оруулаад, холбогдох шинэ, бүтээгдэхүүн, үйлчилгээг болбол нэвтрүүлээд гаргаад явж байгаа. Жишээ нь, бид бүхэн дотоодын зах зээлээс 10 тэрбум төгрөгийн ногоон ирээдүй гэдэг бондыг гаргаж эх үүсвэр татсан байгаа. Энэ нь биржийн бус зах зээл дээр гаргасан анхны бонд байгаа юм, Монгол улсын хэмжээнд. Энэхүү татсан эх үүсвэрээ бид бүхэн Монгол Улсын Ногоон таксономи болон Тогтвортой хөгжлийн сан, тогтвортой хөгжлийн санхүүжилттэй холбоотой ийм шаардлагад нийцсэн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлээд явж байна. Мөн энэ аялал жуулчлалыг дэмжих чиглэлээр ирээдүйн ажлыг болбол Монгол Улсын Засгийн газар хийж байгаа. Үүний хүрээнд гадаадын аялал жуулчлагч нарт таатай нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Монгол Улсын хил дээр tax refund үйлчилгээг нэвтрүүлсэн, мөн банкны нэгжийг ажиллуулаад явж байна. Монгол Улсад анхны доллароор үйлчлэгч АТМ-г нэвтрүүлээд ажиллаж байна. Үүний үр дүнд 209 сая төгрөгийн шимтгэлийн орлогыг бол төвлөрүүлээд байгаа. Хувьцаат компани болсноосоо хойш Төрийн банк дараалан, одоо 3 дахь жилдээ Топ-20 индекст орж, эхний 10-15-д жагсаж байгаа ийм үзүүлэлттэй байна. Төрийн банк нь үйлчилгээгээ иргэдэд хандаж үйлчилдэг, бүтээгдэхүүн үйлчилгээгээ иргэдэд хандаж гаргадаг ийм байгууллага байгаа. Өөрөөр хэлбэл нийт манай харилцагчдын 90 гаруй хувь нь иргэд байдаг. Манай зээлдэгчдийн мөн 90 орчим хувь нь иргэд байдаг. Зээлийн бүтээгдэхүүн нь иргэдэд зориулсан бүтээгдэхүүн байдаг. Энэ ч утгаараа олон улсын хэмжээнд шилдэг иргэдийн банк гэдэг ийм өргөмжлөлийг Global banking & finance байгууллагаас хүртсэн байгаа. Төрийн банк нь 2015 он буюу 10 гаруй жил Топ-100 ААН-ийн эхний 10-15 дугаар байрт жагсаж байгаа. Сүүлийн 5 жил бол дараалан эхний 4-5 дугаар байрт орж байгаа. Төрийн бус ААН-ийн нэгжүүд дотроо

эхний 4-д жагсаж байгаа, ийм амжилттай үзүүлэлттэй байна. Төрийн банк нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэйг иргэд оролцдог Ability expo-2024 гэсэн ийм арга хэмжээнд хамтран ажиллагчаар оролцсон байгаа. Энэ арга хэмжээнд оролцсоноороо “Хүртээмжээр түүчээлэгч бизнес” өргөмжлөлөөр шагнагдсан байна. Санхүүгийн үзүүлэлтүүдийг танилцуулъя та бүхэндээ. Өмнө нь хэлсэн 2009 онд анх үүсгэн байгуулагдахдаа болбол 130 гаруй тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулж байсан бол өнөөдөр оны эцсээр 6,2 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй, өөрөөр хэлэх юм болбол 40 гаруй дахин нэмэгдсэн ийм үзүүлэлттэй байгаа юм. Сүүлийн 3 жилийн энэ үзүүлэлтийг авч үзэх юм бол актив 18,2%-иар өссөн байгаа. Сүүлийн 2024 онийг өмнөх онтой харьцуулахад бол 15,9%-иар өссөн ийм үзүүлэлттэй байна. Нийт активын маань болбол 56 орчим хувийг зээлийн багц эзэлж байгаа. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа 12 банкны хувьд болбол үндсэндээ 50-60 орчим хувийг болбол зээлийн багцдаа төвлөрүүлдэг байгаа. Үнэт цаас буюу хөрөнгө оруулалтын шинжтэй актив болбол 29%-ийг эзэлж байна. Нийт зээлийн хувьд 3,5 их наяд төгрөг хүрсэн байгаа. Өмнөх онтой харьцуулбал 44,1%-иар өссөн ийм үзүүлэлттэй байна. Нийт Төрийн банкны банкны хувьд болбол 480 гаруй мянган зээлдэгч байдаг. Нийт нэг зээлдэгчид дунджаар 7,6 сая төгрөгийн зээл оногдож байгаа. Энэ утгаараа бол зээлийн төвлөрөл бага байна гэж үзэх боломжтой. Дээрээс нь нэг зээлдэгч болон түүнд хамаарах түүнд олгодог зээлийн хэмжээ 5 тэрбум төгрөг байгаа. Энэ нь болбол бусад банкнуудтай харьцуулахад 40-50 дахин бага ийм үзүүлэлттэй байна гэж үзэж болно. Цэвэр ашгийн хувьд сүүлийн 5-6 жилийн хугацаанд өсөлттэй гарч байгаа. Дунджаар сүүлийн 3 жилийн хугацаанд 41,3%-иар өссөн ийм үзүүлэлттэй байна. 2024 оны эцсийн байдлаар 108 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Банк бол эх үүсвэр татаж зуучлалын үйл ажиллагаа явуулдаг ийм байгууллага. Эх үүсвэрийн хувьд 5,6 их наяд төгрөгт хүрсэн байгаа. Энэ нь сүүлийн 3 жилийн дунджаар болбол 18,3%-тай байна. Депозитыг дотор нь ангилаад үзэх юм болбол нийт харилцах 1,4 их наяд төгрөг, хадгаламж 2,8 их наяд төгрөг байна. Нийт депозитын 90 гаруй хувь нь иргэд байдаг ийм бүтэцтэй, манай депозитын хувьд. Зохистой харьцааны хувьд болбол Төрийн банк сар болгон Монголбанканд тайлангаа тавьдаг. Сар болгон бид нар зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг нэлээн өндөр хэмжээгээр болбол хангаж ажиллаж байгаа. Тухайлбал өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа 12% байдаг болбол Төрийн банкны 2024 оны 1 дүгээр улиралд зохистой харьцаа 18,2%-тай байна. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хувьд болбол 25%-тай, 25-аас дээшээ гарах ёстой. Төрийн банк 38,8%-тай байгаа за энэ нь болбол дунджаар 35-аас 40%-тай байдаг ийм үзүүлэлт байгаа. Өөрийн хөрөнгийн өгөөжийн хувьд 20,02%-тай активын өгөөжийн хувьд болбол 2,1%-тай байна. 2024 оны онцлох ажлын хувьд Cargill байгууллагатай бид бүхэн хамтарч ажиллаад 3-4 жил болж байна. Энэ байгууллагаас олон улсын санхүүгийн байгууллагаас 70 сая долларын эх үүсвэрийг бид амжилттай татаж чадсан. Өнөөдрийн байдлаар саяхан бид 45 сая долларыг татаад үйл ажиллагаандаа зарцуулаад байна. Энэхүү 70 сая долларын эх үүсвэрийг бид бүхэн ХАА-г дэмжих зориулалтаар бол авсан байгаа. Зарцуулалт нь бол малчин, тариаланчдад зориулсан

зээлийн бүтээгдэхүүнд зарцуулсан байгаа. Мөн шинэ бүтээгдэхүүн гэх юм бол ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн урт хугацааны даатгалыг болбол анхалж нэвтрүүлсэн байгаа. Өнөөдрийн байдлаар 44 харилцагчид 5 тэрбум төгрөгийн даатгалын үйлчилгээг болбол үзүүлсэн байна. Гялс банкаа бид шинэчилсэн. Гялс банк 3.0 гэсэн хувилбарыг шинэчлээд ажиллаж байна. Үүний үр дүнд бол 7 төрлийн зээлийг болбол цахимаар олгох боломжийг болбол бүрдүүлсэн байгаа. Өнөөдрийн байдлаар 31 мянган зээлийн 220,4 тэрбум төгрөгийн цахим зээлийн багц байна. Эрүүл иргэн гээд манай бүтээгдэхүүн байгаа энэ болбол нэлээдгүй бас амжилттай харилцагч нарын талархлыг хүлээсэн, сэтгэлд нийцсэн ийм бүтээгдэхүүн байгаа. Энэ бүтээгдэхүүнийг бол 5703 харилцагчид 9,8 тэрбум төгрөгийн хадгаламжийг бол бүрдүүлсэн байгаа. Нарру хадгаламж гээд шинэ бүтээгдэхүүнийг гаргасан байна. Мөн жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан Миний Монгол гэсэн ийм үзэсгэлэн худалдааг болбол жил болгон зохион байгуулдаг. Үүний үр дүнд болбол 379 сая төгрөгийн борлуулалтыг тухайн үед бол манай харилцагчид хадгаламж эзэмшигч нар хийсэн байгаа. Мөн уян хатан нөхцөлтэй дотоодын Т картыг зах зээлд нэвтрүүлсэн, 576 хариуцагчид 215,2 сая төгрөгийн картыг болбол олгоод ажиллаж байна. Өмнө нь дурдсан, Засгийн газраас Төрийн банкиг ногоон хөгжлийг дэмжих банк болгож зарласан. Үүний хүрээнд болбол бид нар нэлээдгүй ажлыг хийгээд байна. Цаашдаа ч бас хийхээр төлөвлөөд ажиллаж байгаа. 10 тэрбум төгрөгийн ногоон бондыг амжилттай гаргасан байгаа. Ногоон зээлийн хувьд болбол одоо өмнөх онтой харьцуулахад 108,6%-иар болбол өсгөж 53,6 тэрбум төгрөгт хүрсэн. Тогтвортой хөгжилд чиглэсэн зээлийн хувьд 92,9%-иар өсөж 178 тэрбум төгрөгийн зээлийн багцыг бүрдүүлсэн байна. Тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр хэд хэдэн байгууллагуудтай болбол хамтарч ажиллаж байгаа яам, тамгын газрууд байна. Монголын ногоон санхүүгийн корпораци, Тогтвортой санхүүжилтийн холбоо, Монголын бэлчээр ашиглагчдын холбоо, Зээлийн батлан даалтын сан гэсэн ийм байгууллагуудтай болбол хамтын ажиллагааг өргөжүүлээд ажиллаж байна. Мөн тогтвортой хөгжилд чиглэсэн үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Ногоон ирээдүйг цогцлоох эрчим хүчний хэмнэлтийн шийдлүүдийг санхүүжүүлэх хэсгийг хамтран зохион байгууллаа. Нийгмийн хариуцлагын хүрээнд бид жил болгон бас модыг мод(а) болгоё гэсэн ийм аяныг зохион байгуулж 34 нэр төрлийн 5594 ширхэг модыг болбол тарьсан байна. Үүнийгээ жил болгон арчилж ургуулах тал дээр ажилладаг. Гялс цэвэрлэгээг мөн зохион байгуулдаг. 7000 га талбайгаас 800 тонн хогийг бид нар цэвэрлэж хаясан байна. Эко картыг мөн нэвтрүүлсэн байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Ability expo 2024 үзэсгэлэн худалдаанд хамтран ажилласан, ийм нийгмийн хариуцлагын хүрээнд болбол ажлуудыг хийж байна. Та бүхэндээ үйл ажиллагаа болон санхүүгийн талаарх мэдээллийг хүргэлээ. ТУЗ-ийн үйл ажиллагааг танилцуулна уу, хэмээн ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн таныг урьж байна.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: ТУЗ-ийн хувьд өнгөрсөн онд хэд хэдэн манай ТУЗ-ийн гишүүд албан үүргээ өөрчилсөнтэй холбоотойгоор ТУЗ-өөс гарах өргөдлөө өгсөн. Үүнтэй холбоотойгоор бид Монголбанкны шаардлагын дагуу хараат бус гишүүний

сонгон шалгаруулалтыг бол зарласан. Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор түр ТУЗ-ийн гишүүдийг томилоод бол үйл ажиллагаагаа явуулж байгаа. ТУЗ-ийн бүрэн эрх бол 6 дугаар сард 3 жилийн хугацаа нь бол дуусаж байгаа. Үүнтэй холбоотойгоор бид Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Авилгатай тэмцэх газруудаас зөвшөөрөл ирсний дараа дараагийн ТУЗ-ийг Компанийн тухай хуульд заасан кумулятив аргаар томилох ажлын бэлтгэл хийгдээд явж байгаа. Үүнтэй холбоотойгоор ТУЗ-ийн бүрэлдэхүүнд хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтад ороод шаардлагаа хангаад зохих зөвшөөрлүүд нь ирсэн орны гишүүдийг бол томилж ажилласан. Үүн дээр бол Хандсүрэнгийн Пүрэвсүрэн, Бат-Очирын Цэвэгжав, Зоригтын Оюунцацрал гэсэн ийм хүмүүс бол одоогийн байдлаар ТУЗ-ийн гишүүнд түр томилогдоод ажиллаж байгаа. Өнгөрсөн хугацаанд 2024 онд нийт ээлжит болон ээлжит бусаар бол 18 удаа хуралдаж 66 асуудал хэлэлцэж, 15 үүрэг даалгавар 79 тогтоолоор баталсан байгаа. ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд бол нийт 32 удаа хуралдаж 158 асуудлыг хэлэлцэж 154 шийдвэрүүд гарсан байгаа. Үүнтэй холбоотойгоор ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт бол жилийн эцсийн байдлаар 94,5%-тай байна. Гол ажлууд бол өнгөрсөн жилийн хугацаанд бол бид 1 дүгээрт, Засгийн газраас өгөгдсөн байгаль орчин хүний эрхийг дээдэлсэн Ногоон банк болохтой холбоотой бүтцийн өөрчлөлтүүд, бодлогын шинэчлэлүүдийг хийх дээр анхаарч ажиллалаа. 2 дугаарт, бид компанийн засаглалын сайн туршлагуудыг нэвтрүүлэх чиглэлээр бол онцгой анхаарч ажилласан. Санхүүгийн зохицуулах хорооны нээлттэй компаниудын засаглалын индексээр манай банкны засаглал бол банкнууд дундаа 1 дүгээрт, Монгол улсын ХК-иуд дундаа бол 6 дугаарт жагссан ийм сайн үзүүлэлтийг бол авсан. Нийт үнэлгээ бол 95,8 хувь гэсэн ийм засаглалын үнэлгээтэй бид ажиллаж байна. Түүнчлэн бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санхүүгийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх тал дээр банкнууд дундаа бол тэргүүлж ажилласан байгаа. Хөрөнгийн биржийн Топ-20 импекст бол манай банк тасралтгүй ороод явж байна. Нэмээд хэлэхэд бид Ногоон банк болохтой холбоотойгоор анх удааг Монголд ногоон ирээдүй гэсэн хаалттай бондыг бодлогын хүрээнд бол гаргасан байгаа. Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандартыг бас Монгол улсдаа анх нэвтрүүлсэн гээд ТУЗ-ийн зүгээс болон Гүйцэтгэх удирдлагын зүгээс хамтарч ажиллаж хэрэгжүүлсэн олон ажлууд байгаа. Яг ногоон банктай холбоотойгоор бид тогтвортой хөгжлийн тайланг бас гаргаад энэ чиглэлийн ажлууд бол хийгдээд явж байна. ТУЗ-ийн хувьд бол Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо гээд 4 хороо бол ажиллаж байна. Эдгээр хороод бол бусад банкнууд болон нээлттэй ХК-иудтай харьцуулахад маш идэвхтэй ажилладаг. Яг мэргэжлийн хороод, бүх хороодыг бол хараат бус гишүүдээр ахлуулсан. Манай банкны хувьд, ТУЗ-ийн хувьд бол 4 хараат бус гишүүдтэйгээр бас онцлог байдаг. Тэгээд 4 хараат бус гишүүд нь хороодоо ахалдаг. Бүх асуудлууд хороодоор дамжиж ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэгддэг буюу бид хэчнээн төрийн өмчит боловч хараат бус гишүүд мэргэжлийн ТУЗ-ийн гишүүдийн үүрэг оролцоо хамгийн өндөр түвшинд ажиллахаар бол зорьж ажилладаг. Ийм онцлогтой манай ТУЗ ажиллаж байна. ТУЗ-

өөс хэрэгжүүлж байгаа хяналтын хувьд бол дотоод аудитын хяналт болон хөндлөнгийн аудитын хяналт гэсэн ийм бүтэцтэйгээр бол ажилладаг. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын газар банкны үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичиг, банкны бодлого, журам, зааврын хэрэгжилт, банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангагдаж байгаа эсэхэд хяналт тавих, мөн банкны эрсдэлийн удирдлага, засаглал ба дотоод хяналтын тогтолцоог үнэлж дүгнэх, үйл явцыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, банкны үнэ цэнийг нэмэгдүүлэх чиглэлд ажилладаг. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 33 дугаар тогтоолоор “Төрийн банк” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-тай гэрээ байгуулах зөвшөөрлийг олгон, 2024 оны санхүүгийн тайланд гэрээний дагуу хөндлөнгийн аудит хийлгэсэн байгаа. Өнөөдрийн хэлэлцэх сүүлийн асуудлаар бол хөндлөнгийн аудитын гаргасан аудитын дүгнэлтийг батлахаар байгаа. Ингээд 2024 оны үйл ажиллагаа болбол санхүүгийн тайлантай холбоотой танилцуулгыг та бүхэнд танилцуулж дууслаа. Одоо хөтөлбөр ёсоор 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай танилцуулъя.

Хоёр. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай танилцуулга

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Компанийн тухай хуулийн дагуу ногдол ашиг хуваарилах шийдвэр бол 2024 оны 2 дугаар сарын 19-ний 10 дугаар тогтоолоор бол хуваарилах тухай шийдвэрийг гаргасан байдаг. Компанийн тухай хуулийн 46.15-д заасны дагуу ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал танилцуулах ийм хуулийн зохицуулалттай байдаг. Тэгэхээр бид 2024 оны 10 дугаар тогтоолын дагуу 2023 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлээд 2024 оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөр бүртгэлийн өдрөө тооцоод 4 дүгээр сарын 22-ны өдрөөр ногдол ашиг бол хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилсан. Нийт 755,096,250 ширхэг энгийн хувьцаанд 9211 хувьцаа эзэмшигчдэд нэгж хувьцаанд 66,2 төгрөгийг хуваарилсан. Нийт ногдол ашиг хуваарилсан дүн бол 49.9 тэрбум төгрөгийг бол хуваарилсан байна. Ийм ногдол ашиг хуваарилалтын тайланг бид та бүхэнд танилцуулж байна. Ногдол ашгийг бол бид сүүлийн 2, 3 жил бүрэн танилцуулаад хуваарилаад явж байгаа. Үүнтэй холбоотой ажлууд бол хэвийн, хугацаандаа бүх ажлууд бол хийгдээд явсан.

Гурав. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга

Б.Тэлмүүн, Хурлын дарга: 2024 оны санхүүгийн үр дүнтэйгээс ногдол ашиг хуваарилах тухай танилцуулъя. ТУЗ-ийн 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 32 дахь тогтоолын дагуу 2024 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж барьцаанд 63,70 төгрөг буюу нийт 48,1 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байгаа. Үүний дагуу нийт эргэлтэд байсан 755,096,250 ширхэг хувьцаанд хуваарилж байгаа. Үүнтэй холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 4

дүгээр сарын 10-ны өдрөөр тасалбар болгосон. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 4 дүгээр сарын 25-ны өдөр хувьцаа эзэмшигчдэдээ бол олгосон байгаа. Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон банкны ногдол ашгийн бодлогод заасан бүх шаардлагыг бол ногдол ашиг хуваарилсны дараах үр дүнгээр бол бид нар хангаж ажиллаж байгаа. Үүнтэй холбоотой ногдол ашиг хуваарилах тухай тогтоолыг бол та бүхэнд бол танилцуулсан байгаа. Ингээд танилцуулах асуудлууд бол үүгээр дуусаж байна. Асуулт, хариултын хэсэг рүүгээ оръё. Анхаарал хандуулсанд баярлалаа. Хэлэлцэх асуудлаар санал хэрхэн өгөх тухай зааврыг Тооллогын хорооны комиссын дарга А.Батмөнх танилцуулаад үүний дараа асуулт хариултдаа явчихъя. Энэ хооронд санал өгөх боломж бол нээлттэй байгаа.

А.Батмөнх, Тооллогын комиссын дарга: Тооллогын комиссын гишүүд та бүхний баруун талд байрлаж байгаа. Тооллогын комиссын гишүүд санал авах 2 хайрцгийг байршуулсан байгаа. Явуулын хайрцаг болон тогтмол хайрцаг байршуулсан байгаа. Гараа өргөвөл явуулын хайрцагаар санал авах боломжийг мөн бүрдүүлсэн байгаа. Мөн хурлаас өмнө саналын хуудсаар болон цахим хэлбэрээр санал өгөх боломжийг бүрдүүлж ажилласан байгаа. Та бүхэн санал өгөхдөө саналын хуудасны заавар, зөвлөмж, санамж бичигтэй сайн танилцаарай. Урьдчилж санал өгсөн бол та дахиж санал өгөх боломжгүйг санаарай. Засварласан, балласан залруулгатай хоосон бол саналын хуудас нь хүчингүйд тооцогдохыг анхаарна уу. Мөн цахимаар орж буй бол хэлэлцэх асуудалд санал өгнө. Та бүхэн яг өөрсдийн гар утсаараа statebank.mn сайт руу ороод хөрөнгө оруулагч цэсийн хувьцаа эзэмшигчдийн хурал гэсэн хэсэгт орж зааварчилгаатай танилцах боломжтой. Мөн зүүн дээд буланд байрших санал өгөх хэсэгт дараад саналаа өгөх боломжтой. “Төрийн банк” ХК-ийн ээлжит хурлын саналын хуудас ийм хэлбэрээр харагдаж байгаа. Та бүхэн эдгээр товчийг дараад, илгээхдээ итгэлтэй байна гэдгийг дахин баталгаажуулж, хариултыг өгснөөр санал өгөх боломж бүрдэж байгаа. Хувь хүн болон байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч та саналын хуудсаа саналын хайрцаг болон явуулын саналын хайрцагт заавал хийнэ үү гэдгийг анхааруулъя. Одоо гар утсаараа хэрхэн санал өгөх тухай видео танилцуулга явна, та бүхэн танилцаад санал өгөх боломжтой. Ингээд хурлын даргад микрофоноо шилжүүлъя.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Асуулт, хариултыг эхлүүлъя. 1 асуулт 2 минут, хариулт 2 минутаар явна. Заалны 2 талд микрофон бэлдсэн байгаа. Та бүхэн асуултаа асууна уу.

Хувьцаа эзэмшигч Дөлгөөнтамир: Надад 3 асуулт байна. 1 дүгээр асуулт, 2026 оны 12 дугаар сарын 31 гэхэд системийн 5 банкны нэг хувьцаа эзэмшигчдийн хувьд 20% болох хуультай. Энэ шалгуурыг хангахын тулд Төрийн банк ямар үйл ажиллагаа хийж байгаа вэ? Ямар төлөвлөгөөтэй байгаа вэ? Хугацаандаа энэ шалгуурыг хангаж чадах уу? 2 дугаар асуулт, шинэ хоршоо төсөл хөтөлбөр хэрэгжсэн. Үүнтэй холбоотойгоор төслийн хүрээнд чанаргүй зээлийн хэмжээ яг хэд

байна вэ? гэдэг мэдээлэл авахыг хүсэж байна. Нийт хэдэн төгрөгийн зээл олгосон байгаа вэ? 3 дахь асуулт нь 2025 оны 1 дүгээр улирлын тайлантай танилцсан. Миний хувьд их сэтгэл хангалуун бус сэтгэгдэлтэй үлдсэн. Үнэхээр муу ажилласан байна гэж миний хувьд үзэж байна. Ингэж муу ажиллахад юу нөлөөлсөн бэ? 2025 оны төлөвлөгөө ямар байгаа вэ? 2025 оны эцэст нийт хэдэн төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөж байгаа вэ? 2025 оны төлөвлөгөө нь өнгөрсөн 2024 оны цэвэр ашгаас хэдэн хувиар илүү байхаар төлөвлөсөн бэ?

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Асуулт хариулт явж байх хооронд 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслийг хэлэлцээд үүн дээр санал хураалт явж байх ёстой байгаа. Тэгэхээр асуулт хариултын дундуур хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Саяны асуултад хэлэлцэх асуудлыг танилцуулсны дараа хариулт өгье.

Дөрөв. “Төрийн банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл

Б.Тэлмүүн, Хурлын дарга: 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланд “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК орсон байгаа. Аудитын компанийн аудитыг ахалж ажилласан Хабыл Хайрат ирсэн байгаа. Та бүхэн аудитын компаниас асуух зүйл байвал нээлттэй байгаа шүү, манай хуралд оролцож байгаа. 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланд дүгнэлт өгөх асуудлыг ТУЗ-ийн 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцээд 37 дугаар тогтоол гаргасан байгаа. “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг үндэслээд санхүүгийн тайланг зөрчилгүй, материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан гэж дүгнэснийг хүлээн зөвшөөрч хувьцаа эзэмшигчдийн хуралд дүгнэлтийг танилцуулахыг ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүнд даалгасан тогтоол гарсан. ТУЗ-ийн зүгээс 38 дугаар тогтоолоор 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай асуудлыг хэлэлцээд бизнес болон санхүүгийн төлөвлөгөөний зорилтот түвшин хангагдсан гэж үзэж дүгнэсэн байгаа. Үүнтэй холбоотойгоор та бүхэнд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төслийг танилцуулж байгаа юм. Үүнд Төрийн банкны 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай гэсэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл байгаа. Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Төрийн банкны 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслээд тогтоох нь 1 дүгээрт, “Төрийн банкны 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай. 2 дугаарт, Төрийн банкны 2024 оны санхүүгийн тайланд “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн баталгаажуулсан аудитын тайлан, түүний талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг зөвшөөрсүгэй” гэсэн тогтоолын төслийг өнөөдрийн хурлаар бид нар хэлэлцэн шийдвэрлэхээр байгаа. Иймд та бүхэн асуулт хариултаа, тогтоолын төсөлтэй холбоотой асуултаа хамт

асуух боломжтой. 3 асуулт асуугаад хариултаа өгөөд явчихъя. Асуулт асууж байгаа хүн өөрийгөө танилцуулаад, асуултаа асуугаад явчхаарай.

Хувьцаа эзэмшигч Чинзориг: Сайн байна уу. Хувьцаа эзэмшигч Чинзориг байна. 2024 онд чанаргүй зээл өссөн үү? 2025 онд чанаргүй зээл дээр ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ?

Хувьцаа эзэмшигч Энхболд: Сайн байцгаана уу? Надад 3 асуулт байна. 1 дүгээрт нь ТУЗ дээр жижиг хувьцаа эзэмшигчдийг төлөөлж хүн сонгогдсон уу? Сая ТУЗ-ийн танилцуулгыг сонсоход танилцуулга дээр алга байна. Тийм учраас асууж байна. Жижиг хувьцаа эзэмшигчдээс хүн байх ёстой байх гэж бодож байна. Яагаад гэхээр жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг ТУЗ дээр ямар нэгэн хэмжээгээр хамгаалж байх шаардлагатай болов уу гэж бодож байна. 2 дугаар асуулт удирдлагын зардал гэдэг дээр жаахан ойлгомжгүй юм харагдаад байх юм. Нийт цалин 141.0 сая гээд байсан байх, гэтэл удирдлагын цалин урамшуулал дээр нийт 5.0 тэрбум төгрөг байна. Энэ ямар учиртай вэ? 3 дугаарт, гадаадын санхүүгийн байгууллагуудаас хөрөнгө татсан зүйл байгаа юу?

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Асуусан асуултуудын хариултыг өгчхөөд дараагийн асуултыг явъя. Ө.Гантөр захирал хариулна уу.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Асуулт асуусанд баярлалаа. Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлтөөр нөлөө бүхий банкнууд нэг хувьцаа эзэмшигчийн 20-оос дээш хувь эзэмшихгүй гэдэг заалтууд орсон байгаа. Энэ 2 дахиа сунгагдаад явж байгаа. Энэ дээр Төрийн банкны хувьд тусгай зориулалтын банк учраас энэ заалт хамаарахгүй. Учир нь Монголбанкны Ерөнхийлөгчөөс Төрийн банк энэ заалтад хамаарахгүй гээд 2 удаа албан тоот ирсэн байгаа. Тэгэхээр энэ дээр Төрийн банк ямар нэгэн байдлаар хуулийн заалтыг хангаж ажиллах үүрэг хүлээгээгүй гэж хэлж болно. Шинэ хоршоо төсөл хөтөлбөр гээд явж байгаа. Төрийн банкны хувьд 2015, 2016 оноос малчны зээлийг олгож эхэлсэн. Малчны зээл тухайн үедээ хэрэглээний зориулалтаар олгогдож байсан. Нийт зээлийн 20-30%-ийг нь эзэлдэг байсан ба 400-500 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Малчны зээл маань өөрөө эргэн төлөлт маш өндөр зээл байдаг. Түүхэн хугацааг нь харах юм бол 99,5% нь хугацаандаа төлөгддөг чанартай зээл байгаа. 0,5% нь хугацаа хэтрээд, тодорхой хугацааны дараа эргээд төлөгддөг зээл байгаа. Үүнтэй адил малчны хоршооны зээл хөрөнгө оруулалтын зээл байгаа. Энэ зээлийн хувьд нийтдээ 4900 гаруй хоршоонд 498.0 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Өнөөдрийн байдлаар эргэн төлөлт он гараад хийгдээд явж байна. Ямар нэгэн байдлаар чанаргүйдсэн, хугацаа хэтэрсэн зүйл байхгүй байна. 2025 оны 1 дүгээр улирлын тайлангаар Төрийн банк 13.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Төлөвлөгөөгөөр 12.0 тэрбум төгрөгийн ашигтай ажиллана гэсэн төлөвлөгөөтэй байсан. Цаашдаа ашигт ажиллагааг нэмэгдүүлэх тал дээр нэлээдгүй ажлыг хийхээр төлөвлөж байна. Дотоод болон гадаад нөхцөл байдлаас шалтгаалаад эх үүсвэр татах, эх үүсвэрийн зардал тодорхой хэмжээгээр

өсөх хандлага бол байгаа. Та бүхэн мэдэж байгаа саяхан Монголбанкны бодлогын хүү 2 нэгж хувиар өссөн. 10 байсан бол одоо 12% болсон. Тэгэхээр цаашдаа ч гэсэн эх үүсвэрийн зардал өсөх хандлага бол ажиглагдана. Тэгэхээр энэ дээр Төрийн банкны удирдлагын зүгээс тодорхой арга хэмжээг аваад ажиллана. Чинзориг хувьцаа эзэмшигчийн асуултад хариулъя. 2024 оны чанаргүй зээл өссөн үү, 2025 онд чанаргүй зээл дээр ямар арга хэмжээ авах вэ гэж асуусан байна. Төрийн банкны хувьд чанаргүй зээл төлүүлэх тал дээр нэлээдгүй ажлыг зохион байгуулж ажилладаг. Миний хувьд ажиллаж эхлэхэд 225.0 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байсан. Өнөөдөр байдлаар 190.0 гаруй тэрбум төгрөгийн чанаргүй зээлтэй буюу нэлээдгүй хэмжээгээр буурсан байгаа. Системийн хэмжээнд нийт чанаргүй зээлийн хэмжээ 5,4%-тай байгаа. Төрийн банкны хувьд 5,2%-тай байгаа. Тэгэхээр системийн хэмжээнээс доогуур үзүүлэлттэй байна. 2025 онд бид нар энэ хэмжээгээ бууруулна. Оны эцэс гэхэд 4,69%-д хүргэнэ гэсэн зорилтыг тавиад ажиллаж байна. Шүүхийн болон шүүхийн бус замаар чанаргүй зээлийг төлүүлэх ажлыг манай тусгай активын алба болон нэгжүүд нэлээдгүй хэмжээгээр ач холбогдол өгч ажиллаж байгаа. Үүний үр дүнд чанаргүй зээл тэр хэмжээгээр буурч, тэр хэмжээгээрээ ашигт ажиллагаанд эергээр нөлөөлж байгаа. Ийм үзүүлэлттэй байгаа. 3 дахь асуултаас нь эхлээд хариулъя. Төрийн банк кроспонтент харилцаатай 15 банк байгаа. Олон улсын хэмжээнд хамтарч ажиллаж байгаа. Түүнээс гадна олон улсын санхүүгийн байгууллагуудаас эх үүсвэр татах, зээл авах чиглэлээр 2018 оноос идэвхтэй ажиллаж байгаа. Frontcler болон Cargill гээд 2 байгууллагатай бид нар хамтарч ажиллаад 700.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний эх үүсвэрийг татаж оруулж ирсэн. Энэ хэмжээгээрээ Монгол Улсын нийгэм эдийн засагт эерэг нөлөө үзүүлж байгаа гэж ойлгож байгаа. Энэ эх үүсвэр маань мэдээж урт хугацаатай буюу 2-3 жилийн хугацаатай, харьцангуй бага хүүтэй гэж хэлж болохоор байгаа. Удирдлагын зардлын хувьд 2024 онд авсан цалин, урамшууллын зардал байгаа.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Энхболд хувьцаа эзэмшигчийн жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөлтэй холбоотой асуултад хариулъя. 1 дүгээрт, ТУЗ-ийн бүрэлдэхүүнд Сангийн сайд болон төрийн зүгээс төрийн төлөөллийг бууруулсан. Өмнө нь ердийн гишүүн 6, хараат бус гишүүн 3 гэж байсныг одоо хараат бус гишүүдийн тоог 4 болгож нэмэгдүүлсэн. Үүнтэй холбоотойгоор бид Монголбанк бусад зохицуулагч байгууллагуудын зөвшөөрөл гарсны дараа ТУЗ-ийн бүрэн бүрэлдэхүүнийг шинэчлэх асуудлаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлах шаардлагатай байгаа. Бид хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг явуулахад нийт 9 хүний материал ирсэн. Үүнээс 5 хүний материал хуульд заасан шаардлага хангаад, зохих зөвшөөрөл авах ажиллагаанууд явж байгаа. Тэгэхээр энэ боломж нээлттэй байдаг. Жижиг хувьцаа эзэмшигчдийн хяналттай холбоотойгоор Хяналтын зөвлөл гээд манай банкны дүрэмд байдаг. Бид хяналтын зөвлөлийг байгуулахад өнгөрсөн 2 жилийн хугацаанд 3 удаа сонгон шалгаруулалтыг зарласан

байдаг. Нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдах ёстой. Өнгөрсөн 3 удаагийн сонгон шалгаруулалтад хуульд заасан шаардлага хангасан 7 хүний бүрэлдэхүүн ерөөсөө бүрдэж чадаагүй. Энэ удаагийн сүүлд зарласан сонгон шалгаруулалтаар Нэр дэвшүүлэх хорооноос 7 хүний материалыг шаардлага хангасан гэж үзээд, зохих байгууллагуудаас зөвшөөрөл авах ажиллагаа хийгдэж байгаа. Энэ дээр мөн жижиг хувьцаа эзэмшигч хараат бус, мэргэжлийн хүмүүсээс орж хяналт тавих боломж нээлттэй байгаа. Удирдлагын зардал дээр нэмж хэлэхэд яагаад өссөн юм бэ гэхээр. ТУЗ-ийн зүгээс эрх бүхий албан тушаалтны тоог нэмсэн. 2023 онд нийт 34 банкны захирлуудад эрх бүхий албан тушаалтнуудад хамаардаг байсан. Энэ тоог бид нар 73 болгож нэмэгдүүлсэн байгаа. Салбарын захирлууд болон банкны удирдах албан тушаалтнуудтай хамрах хүрээг нэмэгдүүлсэн байгаа. Үүний гол шалтгаан бол хариуцлага, сахилга батыг нэмэгдүүлэх, хамаарал бүхий этгээдэд зээл олгох, хамаарал бүхий этгээдтэй бизнесийн харилцаанд орох, хэлцэл хийх тохиолдолд заавал ТУЗ-өөс зөвшөөрөл авах шаардлагуудыг нэмсэн. Тэгэхээр орон нутгийн салбарын захирлууд заавал ТУЗ-ийн зөвшөөрлөөр хамаарал бүхий этгээдүүдтэй гэрээ хэлцэлд орохоор шаардлагыг өргөжүүлсэн байгаа. Энэ бол бидний хувьд сахилга бат хариуцлага, ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэлд орохгүй байх арга хэмжээг авсны үр дүнд удирдлагын зардал өссөн гэж харагдаад байгаа юм. Тэгэхээр удирдлагын зардалтай холбоотой зардалд тайлагнадаг, тооцогддог байсан хүний тоо 2 дахин нэмэгдсэнтэй холбоотой өссөн байгаа. Энэ жилийн төлөвлөгөөний хувьд бид цэвэр ашгийг 103,4 тэрбум төгрөг байхаар баталсан. Энэ жилийн хувьд нэлээн онцлог байгаа. Зөвхөн Монгол Улс гэлтгүй гадаад улсын хүчин зүйлүүдтэй холбоотойгоор тодорхойгүй байдлууд нэлээн өндөр байна. Эх үүсвэрийн зардлууд нэлээн нэмэгдэж байна. Он гараад Монголбанк бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн. Төгрөгийн ханш гэхэд гадаад эх үүсвэрийн зардлуудтай холбоотой нэлээн банкны хувьд үйл ажиллагааны эх үүсвэрийн зардлууд нэмэгдэж байгаа сорилтууд байгаа. 2025 оны төлөвлөгөөний хувьд ТУЗ-ийн зүгээс баримталсан бодлого бол үр ашгийг нэмэгдүүлэх, илүү хэмнэлт хийхтэй холбоотой нэлээн зардлыг хассан, танасан бодлогуудыг баримталж байгаа. Үүн дээр хүний нөөцийн зардал, удирдлагын зардалтай холбоотой нэлээн хассан, танасан зүйлүүд бол байгаа. Тэгэхээр бид энэ цэвэр ашгийн зорилтдоо хүрэхийн тулд жилийн дундуур тодорхой төсвийн гүйцэтгэлүүд дээр хяналтаа тавиад, бариад явах бодлогыг баримтлаад явж байна.

Х.Лхагвасүрэн Эрсдэл, Санхүү хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Гүйцэтгэх захирлын орлогч Х.Лхагвасүрэн байна. Хувьцаа эзэмшигч Дөлгөөнтамирын 3 асуултын 2 нь хариулагдаагүй байгаа. Энэ дээр би хариулт өгье. 2026 оны 12 сарын 31-ний өдрөөр нэг хувьцаа эзэмшигчид ногдох хувь Банкны тухай хууль дээр 20% болохоор байгаа. Энэ дээр шалгуур хангахын тулд банк ямар арга хэмжээ авч байгаа вэ, хугацаандаа амжих уу гэж асуусан байна. Банкны тухай хуулийн 36.2.1-ээр манай банк үүсгэн байгуулахдаа тусгай

зориулалтын банк гэсэн зориулалтаар үүсгэн байгуулагдсан байгаа. Тэгэхээр энэ тусгай зориулалтын банканд энэ заалт хамаарах эсэх дээр банкны зүгээс Монголбанканд хандаж тодруулга авсан. Монголбанкнаас ирсэн хариугаар Төрийн банканд энэ заалт хамаарахгүй. Монголбанк 2026 оны 12 дугаар сарын 31-нд хувьцаа эзэмших хувийг 20% болгох заалтыг заавал гаргаж мөрдөх байгаа. 3 дугаар асуулт, шинэ хоршоо төсөл хөтөлбөрийн хүрээнд хэдэн төгрөгийн зээл олгосон байгаа вэ? Энэ дотор чанаргүй зээлийн хувь хэмжээ ямар байгаа вэ, гэсэн асуулт байна. Шинэ хоршоо хөтөлбөрийн зээлийн санхүүжилтэд нийт 8 арилжааны банк оролцож байгаа. Анхны санхүүжилт нийтдээ 500.0 тэрбум төгрөг байсан. Үүнийг дараа нь дахин нэг удаа сунгаад 500.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлээд, нийт 1 их наядын хөтөлбөр хэрэгжиж байгаа. Тэгэхээр 8 банк нь ямар хэмжээний зээлийн багц бүрдүүлэх вэ гэдэг дээр Монголбанкны зүгээс санхүүжилтийн гэрээнд заасан заалтын дагуу тухайн банкны зохистой харьцаа, зээлийн багц төвлөрлийн эрсдэлийг харгалзаж хувь хэмжээг тогтооно гэсэн байгаа. Тэгэхээр манай банкны хувьд Монголбанкнаас тогтоосон хувь хэмжээгээр мөрдөөд ажиллаж байгаа. Одоогийн байдлаар нийт 4,978 хоршооны 14,295 зээлдэгчид 498,5 тэрбум төгрөгийн зээл олгосон. Энэ хувь хэмжээ гүйцсэн байгаа учраас бид одоо хоршооны зээл олголтыг үргэлжлүүлээгүй зогсоосон байна. Одоогоор олгосон зээлүүд дээр чанаргүй зээл үүсээгүй. Хоршооны малчны зээл маань бүтээгдэхүүнийхээ онцлогоос хамаараад улирлын чанартай төлөлт хийгддэг. Эхний төлөлтүүд эхэлсэн одоогийн байдлаар банкны чанаргүй зээл үүсээгүй явж байгаа.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Дараагийн асуулт асуух хүмүүс асуултаа асууна уу.

Хувьцаа эзэмшигч Цэрэнжав: Тусгай зориулалтын банк гэж хувьцаа эзэмшигчдийн анхны хурал дээр яригдаагүй гэж би бодож байна. Төрийн банк байгуулахдаа ЗГ-ын тогтоолоор 2009 оны 10 дугаар сарын 23-нд байна уу даа байгуулагдсан байх гэж бодож байна. Засгийн газраас тогтвортой тусгай банк гэж дурдаагүй байна гэж санагдаж байна. Ямар учраас тусгай банк гэж ярих болов. Энийгээ нэг сайн тайлбарлаж өгөөч. Бусад хувьцаат банкнуудтай жишиж үзэхэд хамгийн сайн жиших банк ХХБ, нэгж хувьцаа 20,000-аас доош орохгүй байгаа. Манай хувьцааны ханш нэрлэсэн үнэдээ ч хүрэхгүй шалан дээр явж байна. ХХБ хувьцаа эзэмшигчдээ нэгж хувьцаанд 20,000 төгрөгөөр өгөх шийдвэр гарсан. Бид 60 төгрөгөөр явж байна. Та бүхэн бас бодоод үз дээ. Бид ямар компанид ажиллаж байна. Ямар үнэ байна вэ? Энэ дээр ТУЗ-ийн дарга тодорхой хариулт хэлнэ үү. Бидний хувьцааны ханш хэзээ нэрлэсэн үнэдээ хүрэх вэ? Бид ядахдаа 1 нэгж хувьцаандаа 1000 төгрөг авч үзэх юм сан. Сангийн яам үүнд нэг хариу өгөөч. Төрийн банкийг байгуулах Засгаас 12 дугаар сарын 25-ны өдөр 100 тэрбум төгрөг сангийн яамаар дамжуулж өөрчлөн байгуулах гэж гарсан. Энэ бондын эргэн төлөлт өнөөдөр дуусаагүй байна. 58.0 тэрбум төгрөгийн өртэй байна. Төрийн банкны 2 давхарт Зоос банкны эрх хүлээн авагч өнөөдөр амьдарсаар байна. Төрийн банк Зоос

банктай хэдий болтол хамтран амьдрах вэ? Энэ төрийн бондын үлдэгдэл 58 тэрбум төгрөгийг хэзээ Сангийн яаманд төлж дуусгах вэ? Энд Зоос банкны 625 жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг давхар хөндөгдөж байгааг анхаарч хариулт өгнө үү.

Хувьцаа эзэмшигч: Миний ярих гэсэн юмыг ерөнхийдөө хэлчих шиг боллоо. Энэ тусгай зориулалтын гэдэг үг өгүүлбэр, тодотгол Төрийн банкны хувьцаа эзэмшиж байгаа 100 хэдэн хүний эрх ашгийг нэлээн хөндөж байна гэж үзэж байна. Төрийн банкны энгийн хадгаламж эзэмшигч байсан тэр цаг үед одоо энэ ХК болчихсон байхад хувьцаа эзэмшигч болж байгаа 2-ын хооронд оногдож байгаа ашгийн хэмжээ адилхан байгаад зогсохгүй, бүүр саяын хэлдэг нэгж хувьцаанд оногдож байгаа үнэ гэдэг бол бүүр болохоо байгаад байна шүү дээ. Тийм болохоор энэ тусгай зориулалтын гэдэг үгнийхээ учрыг олооч гэж хэлмээр байна. Эсвэл бид нарын анхны нэрлэсэн үнэндээ хүргээд ХК-иас компанийн үйл ажиллагааг дахин ХК гэдэг утгаар нь явуулахгүйгээр тусгай зориулалтын гэж явах юм бол хувьцаа эзэмшигчдийн асуудлыг бараг шийдчихмээр харагдах юм. Төрийн мөнгө уйлдаггүй гэдэг шиг л байна шүү. Бусад Хаан банк, ХХБ гэх мэт ХК-иудтай “Төрийн банк” ХК-ийн үйл ажиллагааг харьцуулаад хар даа. Хувьцаа эзэмшигчдийн хувьд ямар ашиг, үйл ажиллагаа болж байна. Үүн дээрээ анхаараач. Төрийн банкны үндсэн үйл ажиллагаа байгаа боловч чухам яг ХК болоод юугаар, яаж өөрчлөгдсөн, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг яаж хамгаалаад байгаа юм бэ? Зөвхөн банкны үндсэн үйл ажиллагааны тухай тайлан болоод байна.

Хувьцаа эзэмшигч: Банкны ололт амжилт үйл ажиллагааг сонслоо. Бодитой асуудал бол нэгж хувьцаанд оногдож байгаа ашиг, хувьцаа эзэмшигчдэд олгож байгаа мөнгөн гол үзүүлэлт. Тэгэхээр энэ талаараа харах юм бол Төрийн банк бусад топ 5 банктай харьцуулахад хэддүгээрт нь явж байна вэ? Анхны нэрлэсэн үнийн хувьд тиймэрхүү байлаа гэхэд нэгж хувьцаанд оногдож байгаа үр өгөөжөөрөө бусад банкнуудтай харьцуулахад ямар түвшинд явж байна вэ? Зүгээр ер нь мөнгөн дүнгээр нь тооцоолоод харах юм бол банкны хадгаламжаас бараг доогуур шахуу яваад байгаа юм шиг харагдаж байна. Өнөөдөр Монголбанк бодлогын хүүг өсгөлөө, банкны хадгаламжийн хүү өснө. Тэгтэл ирэх жил дахиад 10 хүрэхгүй хувийн ашигтай сууж байх юм бол хувьцаа эзэмшигчдийн итгэл үнэмшил буурах хандлага руу явна. Одоо сүүлийн 2 жил дараалаад тэгж явж байна. Ерөнхийдөө хүн бол маш энгийн тооцоолол хийнэ. Банкны ололт амжилтуудыг зарим нь ойлгоно, заримыг нь ойлгохгүй. Тэгэхдээ тоон үзүүлэлтээр зээлийн багц, ангилал, ашиг гээд бүгд 10-15%-ийн өсөлттэй тоо үзүүлэлтүүд гаргаад байдаг. Тэгтэл яг хувьцаанд оногдох мөнгөн дүнгээрээ ямар байна вэ, гэдэг нь хувьцаа эзэмшигчдэд гол үзүүлэлт байх гэж бодож байна. Анх удаа 200 сая төгрөгтэй хувьцаа авсан бол иймэрхүү, 200 сая төгрөгөө банканд хадгалуулсан бол иймэрхүү гэх мэт. Банк ийм ашиг хуваарилна гэдгийг захын хүн маш энгийн бодож ойлгоно. 2 дугаарт, банкны хувьцаа эзэмшигч банкны олон бодлогын асуудлын хаана нь байна вэ? Энэ хүмүүс хувьцаагаа

барьцаалаад зээл авах эрх байна уу? Үр хүүхдээ ипотекийн зээлд хамруулаад банкттайгаа харьцаад зээлд оруулчих боломж байна уу? Банкны хувьцаа эзэмшигчид чинь энэ компанийн гишүүн шүү дээ. Тийм учраас энд дурандаа сууж байгаа байх. Тэгтэл нэг үйлчилгээ дээр нь очоод 20 хүний дараа хөөрхий зогсоод, суугаад байдаг. Өөрийнхөө компанид очирлоод үйлчлүүлэх гээд сууж байгаа юм шиг бид нарт ийм л ойлголт байдаг. Тэгэхээр хувьцаа эзэмшигчидтэй хандсан Компанийн дүрмийн хүрээнд өөрийнхөө байгууллагын онцлогтой тохируулсан бодлого явуулж болох уу?

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: 2021 онд Банкны тухай хуульд өөрчлөлт ороод 2021 ондоо хувьцаа гаргая гээд банкнууд ажилласан. Гэвч зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалаад 2022 оны дундаас хойшоогоо 3 дугаар улиралдаа гаргаж эхэлсэн. Хамгийн анх Төрийн банк хувьцаа гаргасан байгаа. Араас нь Хаан банк, ХХБ, Голомт банк, Хас банк гээд гарсан. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн багтаамж маань өөрөө хэд билээ. Банкнуудын гаргаж байгаа хувьцааны хэмжээ хэд билээ тэрнээсээ шалтгаалаад гарсан хувьцааны үнийн хувьд маш тодорхой хэмжээгээр буурсан. Ганц Хаан банк бол буугаагүй. Тэгэхээр зах зээлийн нөхцөл байдалтай холбоотойгоор үнэ ханш тогтож байгаа. Зах зээлийн ханшид хувьцаа гаргагч тухайн компанид нөлөөлөх боломжгүй, хуулиараа хориотой байдаг. Тэгэхээр энэ бол зах зээлийн зарчмаар явж байгаа гэж ойлгож болно. 2 дугаарт, ногдол ашгийн хувьд Төрийн банк 2, 3 дахиа тарааж байна. Үндсэндээ нийт нэгж хувьцаанд 200 төгрөг тараасан байх. Энэ нь хувь хэмжээгээр тооцох юм бол 15% болж байгаа. Тэгэхээр хадгаламжид байршуулснаас хувьцаа аваад ногдол ашгаа авсан нь илүү үр өгөөжтэй байна гэж харагдаад байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол хувьцаагаа аваад 27 сарын хугацаанд гэсэн үг шүү дээ. Тусгай зориулалтын банктэй холбоотой асуудлыг манай хууль, эрх зүйн хариуцсан дэд захирал Б.Амарсанаа хариулна.

Б.Амарсанаа, Хууль эрх зүй хариуцсан дэд захирал: Хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэндийг хүргэе. Төрийн банк тусгай зориулалтын банк гэдэг дээр тодорхой хариултыг өгье. Банкны тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-д тусгай зориулалтын банк байж болох Банкны тухай хуулийн зохицуулалт байдаг. Төрийн банкны тухайд анх 2009 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 348 дугаар Засгийн газрын тогтоолоор банк байгуулах саналын тухай батлагдсан байдаг. Энэ тогтоолоор төрийн өмчит Төрийн банкийг байгуулагдсан гэж үздэг. 348 дугаар тогтоолын тогтоох хэсгийн 1-д нь Зоос банк дахь төрийн зарим мөнгөн хөрөнгөөр төрийн өмчийн банк байгуулах мөн Монголбанк, Сангийн яам саналыг зөвшөөрч үүсгэн байгуулагчаар Сангийн яамыг томилсугай. Тогтоолын 2 дугаарт банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг хийхэд шаардагдах 100 хүртэл тэрбум төгрөгийг Засгийн газрын бонд гаргахаар шийдвэрлэсүгэй гэсэн байдаг. Тэгэхээр анх Төрийн банк үүсгэн байгуулагдсан 2009 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 348 дугаар тогтоолоор Төрийн банк нь тусгай зориулалтын үндсэн дээр Засгийн газраас 100 тэрбум төгрөг хүртэл бондын эх үүсвэрээр тусгай зориулалтын шинжтэйгээр

үүсгэн байгуулагдсан төрийн өмчит банк гэдэг нь батлагддаг. Мөн Төрийн банк нээлттэй ХК болох ажлын хүрээнд тусгай зориулалтын банк гэдэг асуудлаар иргэдээс тодруулгууд ирж байсан. Энэ холбогдох асуудлаар бид нар төв банканд хандаад төв банкны зүгээс 2 удаагийн төв банкны ерөнхийлөгчийн гарын үсэгтэй албан бичгүүд ирсэн байдаг. Үүн дээр Төрийн банк анх 2009 онд Засгийн газрын эх үүсвэрээр үүсгэн байгуулагдсан тусгай зориулалтын банк юм гэсэн тодорхойлолтуудыг ирүүлсэн байдаг юм. Тэгэхээр түрүүн бас хувьцаа эзэмшигчийн асуултад гарсан нэг хувьцаа эзэмшигчийн 20% хүртэл хязгаарт бол Төрийн банк хамаарахгүй. Тусгай зориулалтын банкны үйл ажиллагаа эрхлээд явж байгаа.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Хувьцааны үнэтэй холбоотой хариулт өгье. Мэдээж хэрэг та бүхэн хувьцаа эзэмшигчийн хувьд ногдол ашгийн өгөөжөө харах нь зүйн хэрэг. Би хэдэн тоо та бүхэнд дурдаад үзүүлчихье. ХХБ-ны нэгж хувьцааны үнэ 33,000 төгрөг гэж гарч байсан. Одоо 26,000 төгрөг байгаа. Бид нар юуг харах нь зүйтэй гэхээр ногдол ашгийн өгөөж. Тэгэхээр жилийн дундаж ханшаас яг ногдол ашгийн өгөөжөө үзэхээр манай банкны хувьд 2024 онд 13%, ХХБ-ны хувьд 7,7%, Хас банкны хувьд 6,5%, Голомт банкны хувьд 9,9% байгаа. Тэгэхээр яг тухайн жилийн дундаж арилжаанд байгаа хувьцаанаас манай ногдол ашгийн өгөөж өндөр байгаа. 2 дугаар үзүүлэлтийн хувьд нийт ашгийнхаа хэдэн хувийг ногдол ашигт өгөөд байгаа юм бэ, гэж үзвэл Төрийн банкны хувьд нийт ашгийнхаа 44,6%-ийг энэ жилийн хувьд ногдол ашигт тарааж байгаа. Голомт банк манай банктай адилхан. ХХБ-ны хувьд цэвэр ашгийнхаа 33,9% Хас банкны хувьд 27,7% гэсэн үзүүлэлтүүд байгаа. ТУЗ-ийн зүгээс хамгийн гол бодлого бол цэвэр ашгаа нэмэгдүүлэх үүнтэй холбоотой ногдол ашгийнхаа өгөөжийг нэмэгдүүлэх юм. Бидний бас нэг хүндрэл бол ногдол ашгаа хэт их тараагаад байхаар эргээд банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний асуудал нь их болоод байдаг. Тэгэхээр бид нар яг энэ 3 баланс дээр тэнцвэрээ хангаад, ногдол ашгийн өгөөжийг аль болох бууруулахгүй байх түвшинд явж байна. Манай ногдол ашгийн өгөөж 2022 онд 9,5% байсан. 2023 онд 12%, 2024 онд 13% гээд өсөж байгаа. IPO-доо хэзээ хүрэх вэ гэдэг дээр энэ бол зөвхөн Төрийн банк гэлтгүй нээлттэй ХК-иас ихэнх байгууллага дээр ийм үзүүлэлтүүд явж байгаа. Манайх 590 төгрөгөөр гарсан өнгөрсөн жилийн дундаж 490 төгрөг орчим төгрөг байна. ХХБ-ны хувьд 33,000 төгрөг гарсан. Өнгөрсөн жилийн дундаж 26,000 төгрөг байна. Голомт банкны хувьд 1,285 төгрөгөөр гарсан. 1,012 төгрөг гээд энэ өөрөө ерөнхийдөө зах зээлийн нийт багтаамж, дээрээс нь маш их олон байгууллагууд нээлттэй зах зээлээс мөнгө татаж байна. Эх үүсвэрийн зардалтай холбоотой асуудал байна. Нийт зах зээлийн мөнгөний ханш инфляцтай холбоотой олон хүчин зүйлийн онцлогууд байна. Хөрөнгийн захын хэмжээнд нийтдээ ингээд явдаг. Банкны ТУЗ-ийн хувьд бид хэчнээн төрийн өмчит ч гэсэн манай ТУЗ-ийн онцлог бол илүү мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлж аль болох хараат бус байдлаар хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилготой байгаа. Ийм ч учраас бид өөрийн хөрөнгийн

өгөөж, ногдол ашгийн өгөөжийг бууруулахгүй байх. Цэвэр ашгийн зорилтуудыг нэлээн өндөр амбицтай түвшинд баталж хэрэгжүүлж, шахаж явж байгаа. Тэгэхээр эдгээр үзүүлэлтүүдийг та бүхэн харьцуулаад харж үзнэ үү, гэж хүсэж байна. Хурлын хөтөлбөрийн дагуу асуулт хариултын хугацаа маань өнгөрөөд явж байна. Одоо санал хураалтаа эхлүүлэе. Үүний дараа завсарлага 20 минут байна. Завсарлагын үеэр та бүхэн ТУЗ болон банкны удирдлагуудаас асуулт асуухад нээлттэй. Санал хураалтаа эхлүүлэе. Анхаарал тавьсан та бүхэндээ баярлалаа.

А.Батмөнх, Тооллогын комиссын дарга: Тооллогын комисс дүнгээ гаргалаа. Та бүхэнд танилцуулъя. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр, №2 Улаанбаатар хот, Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлын саналын дүн нэгдсэн батлах тухай. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалт 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын санал хураалтын дүнг тус тус үндэслэлийг тогтоох нь: 1 дүгээрт, “Төрийн банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 94,69%-ийн ирцтэйгээр, 99,998%-ийг зөвшөөрсөн санал өгсөн тул санал хураалтыг хүчинтэйд тооцсугай. Зөвшөөрсөн тоо 715,021,152 хувь 99,998%-ийн саналтай гарсан тул санал хураалтыг хүчинтэйд тооцсугай.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
715,021,152	99.998 %	15,730	0.002 %	677	0.000 %

Санал хураалтын тооллогын комиссын тогтоолыг ТУЗ-ийн даргад гардуулъя. Хурлын үйл ажиллагааг хааж өгнө үү.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: А.Батмөнх захиралд баярлалаа. Та бүхэнд хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулъя. “Төрийн банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6, 29.2.7 дахь заалт “Төрийн банк” ХК-ийн 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн тогтоох нь: 1 дүгээрт, “Төрийн банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай. 2 дугаарт, “Төрийн банк” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд “Эрнст энд Янг Монголия аудит” ХХК-ийн хийж баталгаажуулсан аудитын тайлан, түүний талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг зөвшөөрсүгэй. Хурлын дарга Б.Тэлмүүн гэсэн тогтоол батлагдаж байна. Ингээд өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудал дуусаж байна. Хурлаар хэлэлцэх асуудлыг амжилттай баталлаа. Хувьцаа

эзэмшигчдийн ээлжит хуралд идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигч та бүхэнд талархлаа илэрхийлье. Эрүүл энх сайн сайхныг хүсэн ерөөе. Хурал хаасныг мэдэгдье. /Алх цохив/

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. “Төрийн банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлав.
2. “Төрийн банк” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд “Эрнст энд Янг Монголия аудит” ХХК-ийн хийж баталгаажуулсан аудитын тайлан, түүний талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрөв.

ХУРЛЫН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

A handwritten signature in black ink.

Э.УЯНГА